

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/064/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/064/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.04

№

124

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн данснаас Төрийн хэмнэлтийн хууль зөрчин өмнөх онд өр төлбөрөөр бүртгээгүй 16,200.0 мянган төгрөгийг сумын 100 жилийн ойн өр, гарын бэлгийн төлбөрт шилжүүлж, төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт санхүүжилтийн дансаар иргэнээс 15,000.0 мянган төгрөгийн хандив хүлээн авч, 8,000.0 мянган төгрөгийг Шижигтийн боргио групп ХХК-д худаг уст цэг тогтооход шилжүүлж, 2,735.0 мянган төгрөгийг шатахууны зардалд, 2,000.0 мянган төгрөгийг мод худалдан авахад, 1,950.0 мянган төгрөгийг гэр зуслан ажиллуулахад, 315.0 мянган төгрөгийг бусад бараа үйлчилгээний төлбөрт зарцуулсан,

.. 822505000174

- Нийт 5,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, компьютерыг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй,
- Батлагдсан төсөвт тусгагдаагүй унаа, хоолны хөнгөлөлтөд 32,773.0 мянган төгрөгийг олгосон,
- Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 4,747.5 мянган төгрөгийн шатахууны өр төлбөр үүсгэсэн,
- Төрийн аудитын байгууллагаас 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 01/78, 03/78, 2025 оны 04/113 дугаар төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 25 дугаар зүйлийн 25.2, 27 дугаар зүйлийн 27.1.7, 42 дугаар зүйлийн 42.7, 70 дугаар зүйлийн 70.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.2.5, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэлгээ хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын Засаг дарга зөвшөөрснөөр Засаг даргын нөөц хөрөнгийг нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох, байгалийн гамшигт үзэгдэл цасан болон шороон шуурганд уруудсан мал, төөрсөн хүн эрж хайх зэрэг шатахууны зардалд зарцуулан тайлагнажээ.

Орон нутгийн төсвөөс 1,078,875.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан бөгөөд нэмэлт төсөв 74,271.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5,800.0 мянган төгрөгийн, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 202,324.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бүртгэлд тусгасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу ажил гүйлгээг бүртгэж тайлагнаагүй, дотоод хяналт үр нөлөөгүй зэрэг нь төсвийг үр ашиггүй зарцуулах, өр төлбөр үүсэх эрсдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 3 хөтөлбөр, 10 зорилт, 80 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг сумын Засаг даргаас нийт дүнгээр 96.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Нэг. Хараат бус аудитын дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан


2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН СТ-1 (ТӨГРӨГӨӨР)

Данс-ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>127,053,660.00</u>	<u>144,366,060.00</u>
33	АВЛАГА	3,000,000.00	3,000,000.00
335	Бусад авлага	3,000,000.00	3,000,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,000,000.00	3,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	124,053,660.00	141,366,060.00
354	Хангамжийн материал	15,823,660.00	33,136,060.00
35410	Бичиг хэргийн материал	335,000.00	47,400.00
35420	Аж ахуйн материал	2,868,360.00	2,868,360.00
35470	Бусад хангамжийн материал	12,620,300.00	30,220,300.00
35600	Мал амьтад	108,230,000.00	108,230,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,601,777,183.79</u>	<u>1,555,575,849.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,601,777,183.79	1,555,575,849.01
392	Биет хөрөнгө	1,600,705,183.79	1,554,389,849.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,591,321,822.73	1,591,321,822.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	(500,669,597.15)	(622,468,830.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,361,583.00	205,671,583.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(62,759,803.62)	(85,856,949.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	411,456,007.00	477,156,007.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(203,265,272.16)	(255,050,275.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	305,610,198.00	326,610,198.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,901,108.26)	(119,251,311.02)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	9,430,000.00	9,430,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,350,000.00	42,350,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,028,645.75)	(16,322,395.71)
39217	Ном	800,000.00	800,000.00
393	Биет бус хөрөнгө	1,072,000.00	1,186,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,072,000.00	1,186,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,728,830,843.79</u>	<u>1,699,941,909.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>4,747,528.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,747,528.00
413	Өглөг	-	4,747,528.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,747,528.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,728,830,843.79</u>	<u>1,695,194,381.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,728,830,843.79	1,695,194,381.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	515,312,046.00	515,312,046.00
51101	Өмч: - төрийн	515,312,046.00	515,312,046.00
512	Хуримтлагдсан үр дүн	655,562,910.16	621,926,447.38
51210	Өмнөх үеийн үр дүн	29,431,710.65	655,562,910.16
51220	Тайлант үеийн үр дүн	626,131,199.51	(33,636,462.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	557,955,887.63	557,955,887.63

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,728,830,843.79</u>	<u>1,699,941,909.01</u>
---	--	--------------------------------	--------------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан СТ-2 (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,802,882,253.00	1,373,091,104.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	740,847,775.00	219,924,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	740,847,775.00	219,924,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	740,597,775.00	202,324,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	250,000.00	17,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,062,034,478.00	1,153,167,104.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	161,161,578.00	74,271,404.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		21,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,179,578.00	49,351,172.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	982,000.00	3,920,232.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	900,872,900.00	1,078,895,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	900,872,900.00	1,078,895,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,175,775,744.89	1,406,727,566.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,175,775,744.89	1,406,727,566.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,100,709,036.79	1,274,205,643.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,327,914.32	730,718,442.91
210101	Үндсэн цалин	285,210,870.72	383,473,445.04
210102	Нэмэгдэл	296,686,637.66	293,940,886.54
210104	Урамшуулал	3,064,000.00	1,779,861.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	51,524,250.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,271,900.00	88,658,649.51
210201	Тэтгэврийн даатгал	62,751,900.00	59,259,326.86
210202	Тэтгэмжийн даатгал	5,630,000.00	7,164,922.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,815,000.00	3,741,566.58
210204	Ажилгүйдлийн даатгал	2,815,000.00	3,698,969.51
210205	Эрүүл мэндийн даатгал	11,260,000.00	14,793,864.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,107,547.58	52,855,761.98
210301	Гэрэл, цахилгаан	2,241,564.33	3,000,000.00
210302	Түлш, халаалт	36,865,983.25	49,855,761.98
2104	Хангамж, бараа материалын зардал	33,209,013.00	24,293,208.00
210401	Бичиг хэрэг	5,944,850.00	2,180,380.00
210402	Тээвэр, шатахуун	20,460,113.00	15,647,428.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,359,000.00	1,982,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,385,050.00	4,483,200.00
2105	Нормативт зардал	-	2,450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,990,620.00	6,793,500.00
210604	Урсгал засвар	18,990,620.00	6,793,500.00



Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	13,771,500.00	14,382,000.00
210702	Дотоод албан томилолт	13,771,500.00	14,382,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,941,331.00	1,142,576.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	592,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,176.00	110,176.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,089,210.89	352,911,504.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,686,670.00	93,590,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,920,000.00	4,996,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	168,482,540.89	254,325,334.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,066,708.10	132,521,923.60
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,054,842.10	132,521,923.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,054,842.10	132,521,923.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>627,106,508.11</u>	<u>(33,636,462.78)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>626,131,199.51</u>	<u>(33,636,462.78)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,118,034,478.00</u>	<u>1,153,167,104.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,062,034,478.00</u>	<u>1,153,167,104.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	161,161,578.00	74,271,404.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		21,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,179,578.00	49,351,172.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	982,000.00	3,920,232.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	900,872,900.00	1,078,895,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	900,872,900.00	1,078,895,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,012,709,378.00</u>	<u>1,147,367,104.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,012,709,378.00</u>	<u>1,147,367,104.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>937,642,669.90</u>	<u>1,014,845,180.40</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,327,914.32	730,718,442.91
210101	Үндсэн цалин	285,210,870.72	383,473,445.04
210102	Нэмэгдэл	296,686,637.66	293,940,886.54
210104	Урамшуулал	3,064,000.00	1,779,861.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	51,524,250.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,271,900.00	88,658,649.51
210201	Тэтгэврийн даатгал	62,751,900.00	59,259,326.86
210202	Тэтгэмжийн даатгал	5,630,000.00	7,164,922.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,815,000.00	3,741,566.58
210204	Ажилгүйдлийн даатгал	2,815,000.00	3,698,969.51



Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	11,260,000.00	14,793,864.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,248,721.58	52,855,761.98
210301	Гэрэл, цахилгаан	2,241,564.33	3,000,000.00
210302	Түлш, халаалт	42,007,157.25	49,855,761.98
2104	Хангамж, бараа материалын зардал	32,744,013.00	19,258,080.00
210401	Бичиг хэрэг	5,479,850.00	1,892,780.00
210402	Тээвэр, шатахуун	20,460,113.00	10,899,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,359,000.00	1,982,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,385,050.00	4,483,200.00
2105	Нормативт зардал	-	2,450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,990,620.00	6,793,500.00
210604	Урсгал засвар	18,990,620.00	6,793,500.00
2107	Томилолт, зочны зардал	13,771,500.00	14,382,000.00
210702	Дотоод албан томилолт	13,771,500.00	14,382,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,941,331.00	1,142,576.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	592,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,176.00	110,176.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,346,670.00	98,586,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,426,670.00	93,590,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,920,000.00	4,996,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,066,708.10	132,521,923.60
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,054,842.10	132,521,923.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,054,842.10	132,521,923.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>105,325,100.00</u>	<u>5,800,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	105,325,100.00	5,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,325,100.00	5,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	105,325,100.00	5,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	105,325,100.00	5,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(105,325,100.00)</u>	<u>(5,800,000.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТ-4

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	515,312,046.00	557,955,887.63	29,431,710.65	1,102,699,644.28
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	515,312,046.00	557,955,887.63	29,431,710.65	1,102,699,644.28
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	626,131,199.51	626,131,199.51

Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	515,312,046.00	557,955,887.63	655,562,910.16	1,728,830,843.79
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	515,312,046.00	557,955,887.63	655,562,910.16	1,728,830,843.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	515,312,046.00	557,955,887.63	655,562,910.16	1,728,830,843.79
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(33,636,462.78)	(33,636,462.78)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	515,312,046.00	557,955,887.63	621,926,447.38	1,695,194,381.01

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан СТ-4-1

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,078,895,700.00	948,943,010.40	129,952,689.60	88.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,078,895,700.00	948,943,010.40	129,952,689.60	88.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	981,161,400.00	948,943,010.40	32,218,389.60	96.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,185,200.00	730,718,442.91	4,466,757.09	99.4
210101	Үндсэн цалин	388,647,600.00	383,473,445.04	5,174,154.96	98.7
210102	Нэмэгдэл	279,817,600.00	293,940,886.54	(14,123,286.54)	105.0
210104	Урамшуулал	6,000,000.00	1,779,861.00	4,220,139.00	29.7
210105	Гэрээт ажлын хөлс	60,720,000.00	51,524,250.33	9,195,749.67	84.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,273,200.00	88,658,649.51	3,614,550.49	96.1
210201	Тэтгэврийн даатгал	62,047,000.00	59,259,326.86	2,787,673.14	95.5
210202	Тэтгэмжийн даатгал	7,369,100.00	7,164,922.48	204,177.52	97.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,809,500.00	3,741,566.58	67,933.42	98.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,809,500.00	3,698,969.51	110,530.49	97.1
210205	Эрүүл мэндийн даатгал	15,238,100.00	14,793,864.08	444,235.92	97.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,223,000.00	52,855,761.98	7,367,238.02	87.8
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210302	Түлш, халаалт	57,223,000.00	49,855,761.98	7,367,238.02	87.1
2104	Хангамж, бараа материалын зардал	23,000,000.00	17,358,080.00	5,641,920.00	75.5
210401	Бичиг хэрэг	2,250,000.00	1,892,780.00	357,220.00	84.1
210402	Тээвэр, шатахуун	13,750,000.00	8,999,900.00	4,750,100.00	65.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	1,982,200.00	417,800.00	82.6

**Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	-	100,000.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	4,483,200.00	16,800.00	99.6
2105	Нормативт зардал	2,450,000.00	2,450,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,450,000.00	2,450,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,600,000.00	6,793,500.00	2,806,500.00	70.8
210604	Урсгал засвар	9,600,000.00	6,793,500.00	2,806,500.00	70.8
2107	Томилолт, зочны зардал	14,400,000.00	14,382,000.00	18,000.00	99.9
210702	Дотоод албан томилолт	14,400,000.00	14,382,000.00	18,000.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,230,000.00	1,142,576.00	1,087,424.00	51.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	592,400.00	207,600.00	74.1
210803	Даатгалын үйлчилгээ	660,000.00	-	660,000.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	110,176.00	39,824.00	73.5
210805	Тээврийн хэрэгс-лийн оношилгоо	90,000.00	-	90,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	440,000.00	60,000.00	88.0
210807	Газрын төлбөр	30,000.00	-	30,000.00	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,800,000.00	34,584,000.00	7,216,000.00	82.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,800,000.00	29,588,000.00	7,212,000.00	80.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	4,996,000.00	4,000.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,734,300.00	-	97,734,300.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,734,300.00	-	97,734,300.00	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,734,300.00	-	97,734,300.00	0.0

2.5.2 Нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	(төгрөгөөр) Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,271,404.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,271,404.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,702,170.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,900,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,900,000.00



2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,802,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,802,170.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,569,234.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,569,234.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,569,234.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	74,271,404.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,271,404.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,351,172.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,920,232.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 18,920.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Нэмэлт санхүүжилтийн 18,920.2 мянган төгрөгийн орлогыг эдийн засгийн ангилал зөрүүлж тайлагнасныг залрууллаа.

Залруулагдаагүй 74,520.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 74,520.5 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрч 31,200.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах 2 албан шаардлага, 4,747.5 мянган төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл оногдуулах 1 албан шаардлага, 38,573.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

3.2 Албан шаардлага

1. Нэмэлт санхүүжилтийн данснаас Төрийн хэмнэлтийн хууль зөрчин өмнөх онд өр төлбөрөөр бүртгээгүй 16,200.0 мянган төгрөгийг сумын 100 жилийн ойн өр дарах, гарын бэлэг олгон төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт санхүүжилтийн дансаар иргэнээс 15,000.0 мянган төгрөгийн хандив хүлээн авч, 8,000.0 мянган төгрөгийг Шижигтийн боргио групп ХХК-д худаг уст цэг тогтооход шилжүүлж, 2,735.0 мянган төгрөгийг шатахууны зардалд, 2,000.0 мянган төгрөгийг мод худалдан авахад, 1,950.0 мянган төгрөгийг гэр зуслан ажиллуулахад, 315.0 мянган төгрөгийг бусад бараа үйлчилгээний төлбөрт зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно", 25.4-т "Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно", 25.5-т "Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт санхүүжилтийн дансанд хандив авч зарцуулалт хийхгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Төрийн аудитын байгууллагаас 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 01/78, 03/78, 2025 оны 04/113 дугаартай төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 4,747.5 мянган төгрөгийн шатахууны өр төлбөрийн үлдэгдэлтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батбаатарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг төсвийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлийн зардлаар дэс дараалуулан харуулав. Үүнд:

Нэг. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

1. Илрүүлэлт: Батлагдсан төсөвт тусгагдаагүй унаа хоолны хөнгөлөлтөд 32,773.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд төсвийг зарцуулж байх.

Хоёр: Хөрөнгийн зардалтай холбоотой

2. Илрүүлэлт: Цахим дэлгүүрээс 5,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, компьютер худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг бусад этгээдээс худалдан авахгүй байх.

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар залруулсан алдаа, илэрсэн зөрчлийн нэгтгэл:

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	(мянган төгрөгөөр)											
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	тоо	Дүн	тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар	Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт санхүүжилтийн 18,920.2 мянган төгрөгийн орлогыг эдийн засгийн ангилал зөрүүлж тайлагнасан.	1	18,920.2	-	-	1	18,920.2	1	18,920.2	-	-	-	-
	Дүн	1	18,920.2	-	-	1	18,920.2	1	18,920.2	-	-	-	-



Хөхмөрэт сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгаасан санхүүгийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн	Үүнээс:									
			Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Хөхмөрэт сумын Засаг даргын Тамгын газар	Цахим дэлгүүрээс 5,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, компьютер худалдан аваагүй.	1	5,800.0	-	-	-	-	-	-	1	5,800.0	
	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр нэмэлт санхүүжилтийн дансаар иргэнээс 15,000.0 мянган төгрөгийн хандив хүлээн авч, 8,000.0 мянган төгрөгийг Шижигтийн боргио групп ХХК-д худга уст цэг тогтооход шилжүүлж, 2,735.0 мянган төгрөгийг шатахууны зардалд, 2,000.0 мянган төгрөгийг мод худалдан авахад, 1,950.0 мянган төгрөгийг гэр зуслан ажиллуулахад, 315.0 мянган төгрөгийг бусад бараа үйлчилгээний төлбөрт зарцуулсан.	1	15,000.0	-	-	1	15,000.0	-	-	-	-	
	Нэмэлт санхүүжилтийн данснаас Төрийн хэмнэлтийн хууль зөрчин өмнөх онд өр төлбөрөөр бүртгээгүй 16,200.0 мянган төгрөгийг сумын 100 жилийн ойн өр дарах, гарын бэлэг олгон төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	16,200.0	-	-	1	16,200.0	-	-	-	-	
Хөхмөрэт сумын Засаг даргын Тамгын газар	Батлагдсан төсөвт тусгагдаагүй унаа хоолны хөнгөлөлтөд 32,773.0 мянган төгрөгийг олгосон.	1	32,773.0	-	-	-	-	-	-	1	32,773.0	
	Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02/140 дугаар төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй, Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд 4,747.5 мянган төгрөгийн шатахууны өр төлбөр үүсгэсэн.	1	4,747.5	-	-	-	-	-	1	4,747.5	-	
Нийт		5	74,520.5	-	-	2	31,200.0	1	4,747.5	2	38,573.0	



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтий	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		